

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН
ЗӨВЛӨМЖ

2024.01.15

Дугаар 2024/01

Улаанбаатар хот

“Дүүргийн төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа,
Бодлогын баримт бичгийн 2023 оны үйл ажиллагааны
гүйцэтгэлийн тухай”

Үнэлгээний ажлыг гүйцэтгэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон бусад холбогдох эрх зүйн актуудыг удирдлага болгосон бөгөөд харьяа байгууллагын үйл ажиллагаанд анхаарах дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД

- Бодлогын хэрэгжилт буюу төлөвлөсөн арга хэмжээний зэрэг, сөрөг үр нөлөөний талаарх тоон үзүүлэлтийг агуулга, зорилгоор нь нэгтгэн өсөлт бууралтыг харьцуулж хувиар илэрхийлэх,
- Тайлант хугацаанд ямар нэг өөрчлөлт ороогүй, шинээр ямар нэг юм хийгдээгүй тохиолдолд шалтгаан нөхцөлийн талаар тайлбар бичих,
- Үр дүнгүй болон эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнд онцгой анхаарч, хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг орхигдуулалгүй, найруулга зүйн алдаагүй, 2000 тэмдэгтэд багтаан тоон үзүүлэлтийн өөрчлөлт, үр дүнг нягталж тусгах нь зүйтэй.

3.1 Дүүргийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөөс үр дүнгүй хэрэгжилттэй 7 арга хэмжээ:

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх түвшин
ХОЁР. ЭРҮҮЛ ДҮҮРЭГ – ХҮНИЙ ХӨГЖИЛ			

2.1. Биеийн тамир, спорт

2.1.5 Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан стандарт талбай, спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Дүүргийн спорт цогцолборын барилга шинээр барих ажлыг хэрэгжүүлнэ.	ТГУХ, ТНААХ	Барилгын ажлын явц 50 хувьд хүрсэн байна.
---	--	-------------	---

2.2. Эрүүл мэнд

2.2.7. Жишиг нэгдсэн эмнэлгийн загвараар дүүрэгт нэгдсэн эмнэлэг байгуулна.	Жишиг нэгдсэн байгуулах хамтран байгуулна.	загвараар эмнэлэг ажлыг зохион	ТГУХ, ХУДНЭ	Барилгын ажлын гүйцэтгэлээр 70 хувьд хүрсэн байна.
---	--	--------------------------------	-------------	--

ДӨРӨВ. НИЙГМИЙН ХӨГЖИЛ - ӨРХ БҮРТ

4.5. Гэр бүл

4.5.1 Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж, Хүүхэд, гэр бүлд зэлтэй байгууллага, шилдэг гэр бүлийг шалгаруулан олон нийтэд сурталчилна.	Гэр бүлийн хөгжлийг дэмжих туршилтын хөтөлбөрт хамрагдаж буй 250 өрхийг хөгжлийн үйлчилгээнд хамруулж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.	НХХ, ГБХЗХХ	75 өрхийн амьжиргаа дээшилж, төслөөс хасагдсан байна.
---	--	-------------	---

4.5.3 Төр хувийн хэвшлийн түншлэлээр залуу иргэд гэр бүлээрээ амрах зориулалт бүхий "Эко зуслангийн хотхон, зуслангийн түрээсийн байр" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Залуу иргэд гэр бүлээрээ амрах зориулалт бүхий "Эко зуслангийн хотхон, зуслангийн түрээсийн байр" байгуулж ашиглалтад оруулна.	ТГУХ, ТНБГХХ	Эко зуслангийн барилгын ажлыг эхлүүлнэ.
4.5.4 Залуучуудын хөгжлийг дэмжих, нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Залуучуудын уулзалтыг байгуулах	Чуулга зохион НХХ, ГБХЗХХ	500-аас доошгүй залуучуудыг чуулга уулзалтад оролцуулна.

ТАВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ - ХОРОО БҮРТ

5.1 Газрын харилцаа

5.1.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг Улсын хаягийн нэгдсэн системтэй холбож, хаягжилтын нэгдсэн стандартад шилжүүлэх ажлыг талуудтай хамtran дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна.	Дүүргийн нутаг дэвсгэр дэх геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого хийж, бүртгэлжүүлэх, хадгалалт, хамгаалалтыг эзэнжүүлэх	ГЗБА	Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн хадгалалт хамгаалалтыг эзэнжүүлж гэрээ байгуулна 70 хувь.
--	---	------	---

5.4 Хоггүй Хан-Уул

5.4.3 Гэр хорооллын айл өрхүүдийг үnsийг ангилан хадгалах, савтай болгох, үnsийг дахин боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.	Гэр хорооллын айл өрхүүдийн үnsийг ангилан хадгалах, савтай болгох, үnsийг дахин боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.	ТНААХ	Гэр хорооллын айл өрхүүдийн үnsийг ангилан хадгалах, савтай болгох, үnsийг дахин боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
--	--	-------	--

3.2 Эрчимжүүлэх шаардлагатай 3 арга хэмжээ:

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх түвшин
------------------------------------	----------------------------------	-------------------------	--------------

ХОЁР. ЭРҮҮЛ ДҮҮРЭГ – ХҮНИЙ ХӨГЖИЛ

2.2. Эрүүл мэнд

2.2.9 Харшлын өвчин үүсгэгч ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах зорилгоор "Харшилгүй эрүүл дүүрэг" аян жил бүр зохион байгуулна.	"Харшилгүй эрүүл дүүрэг" аян жил бүр зохион байгуулж, олон нийтийн оролцоог хангана.	НХХ, ТНААХ	Сургалтыг зохион байгуулж, 4000-аас доошгүй иргэнийг хамруулна.
---	--	---------------	---

ДӨРӨВ. НИЙГМИЙН ХӨГЖИЛ - ӨРХ БҮРТ

4.3. Хөдөлмөр эрхлэлт

4.3.2 Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ.	Шилдэг "Старт-ап" 2 багийг сонгон шалгаруулах, Старт-ап залуучуудад ментор хийх	ХөХҮХ	4 баг.
--	---	-------	--------

4.5. Гэр бүл

4.5.1 Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж, Хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага, шилдэг гэр бүлийг шалгаруулан олон нийтэд сурталчилна.	Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан Төрөлт, гэрлэлтийн бүртгэлийг бүртгэх	HXX, CO, ГБХЗХХ	100 иргэн хамруулна.
---	--	-----------------	----------------------

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ЧИГҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД

4. Дүүргийн Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээний биелэлтийг Засгийн газрын 2022 оны 374 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4, 7 дугаар хавсралтын дагуу тус тус боловсруулж хугацаанд нь тайлagnаж хэвших,

4.1 Дүүргийн Засаг даргатай байгуулах Хариуцлагын гэрээ болон байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд холбогдох журмын дагуу Засаг даргын Тамгын газраас санал авч, тусган хэрэгжүүлэх,

4.2 Бодлогын баримт бичгийг төлөвлөхдөө шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг зөв тодорхойлж, хэрэгжилтийг тайлагнахдаа шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд нийцэхүйц тоон үзүүлэлт бүхий чанарын үр дүнг голчлон өмнөх тайлант үетэй харьцуулах байдлаар өсөлт бууралтыг тусгах,

5. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын зөвлөмжийн дагуу төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн биелэлтийг жилийн эцэст тайлагнах,

6. Хяналт, шалгалтын байгууллагаас өгсөн зөвлөмж, актын хэрэгжилтийг мэдээлэхдээ тодорхой, тоо, чанарын үзүүлэлтэй, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний хамт тусган цаасан дээр буулгаж (цахимаар тайлагнасан ч) эрх бүхий албан тушаалтнаар хянуулж, баталгаажуулж, архивлах,

7. Монгол Улсын Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын хэрэгжилтийг хангаж, 6.3.4.3; 6.3.4.4; 6.3.4.5; 6.3.5.4 заалтыг мөрдөж албан хаагчдын баримт бичиг боловсруулах чадавхийг сайжруулахад анхаарч, чанарын шаардлага хангасан архивын баримтын нөхөн бүрдүүлэлтийг журмын дагуу хугацаанд нь хийж гүйцэтгэх,

8. Байгууллагаас гаргаж буй захирамжлалын баримт бичгийн эрх зүйн үндэслэлийг тогтоохдоо холбогдох эрх зүйн актыг судалж, боловсруулах, хавсралтын бүрдлийг хангах, баримт бичгийг боловсруулахдаа “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар” “Баримт бичгийн стандарт MNS 5140-1:2011, MNS 5140-2:2011, MNS 5140-3:2011, стандартыг хангах,

9. Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн тусгай төрлийн баримт /кино, гэрэл зураг, дүрс бичлэг, дуу авиа, зураг төсөл, цахим /ыг архивт тухай бүр нэр төрөл тус бүрээр нь ТААҮЗааврын /хүснэгт 6,15,16,17,18,19,20/ дагуу бүртгэл үйлдэж хүлээлцэж хэвших,

10. Удаа дараа давтагдаж буй санал, хүсэлт, гомдолд онцгой анхаарах, агуулгаар нь ангилж, тухайн байгууллагын шуурхай болон даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, таслан зогсоох үр дүнтэй арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж үр дүнг тооцож, харьяа дээд шатны байгууллагуудад тайлагнах,

11. Албан хаагчид ээлжийн амралттай эсвэл түр хугацаагаар эзгүй хугацаанд ирсэн өргөдөл гомдол, албан бичгийг түүний ажыг түр орлон гүйцэтгэж буй албан хаагч тогтмол шалган хариуцлагатай хандаж, хугацаанд шийдвэрлэх, хэрэв хугацаа хэтрүүлж, зөрчил тооцуулсан тохиолдолд түр орлож буй албан хаагчид хариуцлага тооцох,

12. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх албан хаагчдын ойлголт, хандлагыг дээшлүүлэх сургалтыг холбогдох төрийн бус байгууллагуудаас тогтмол авч, хамтран ажиллаж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД

13. Дүүргийн Засаг даргын 2022 онд баталсан хуваарийн дагуу Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хориглосноос бусад мэдээллийг дүүргийн болон байгууллагын цахим хуудсанд хуулийн хугацаанд байршуулах,

14. Дүүргийн цахим хуудсанд байгууллагын үйлчилгээний нэр төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, зохицуулалтын үйлчилгээний төлбөрийн хэмжээ, төлөх дансны мэдээллийг тухай бүр шинэчилж хэвших,

15. Орон нутгийн өмчит байгууллагууд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явцыг цахим хуудсандаа хуулийн хугацаанд байршуулах,

16. Байгууллагын албан ёсны цахим хуудсаа Хан-Уул дүүргийн албан ёсны www.khanuul.mn цахим хуудастай холбож, мэдээллийн баяжилтыг тогтмол хийж, иргэдэд ойлгомжтой байдлаар мэдээллийг нээлттэй болгох чиглэлээр бүх сурвалжийг ашиглах,

17. Дүүргийн [khanuul.mn](http://www.khanuul.mn) цахим хуудсанд байршуулах өөрийн байгууллагатай холбоотой, хуулинд заасан мэдээллүүдийг Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтанд хугацаанд нь өгч, тухай бүр шинэчлэлт, баяжилтыг тусгуулах албан тушаалтныг хэлтэс, байгууллага бүр дотооддоо томилж, албан тушаалын тодорхойлолтод нь нэмэлтээр тусган ажлын үр дүн, гүйцэтгэлийг тооцож, дүгнэн хариуцлагажуулж ажиллах нь үр дүнтэй.

**ДӨРӨВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ
БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

18. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус төр, хувийн хэвшил, хамт олны хүрээнд өмнө жилүүдэд тарьсан бүх мод, бут, сөөгний арчлалт, хамгаалалт, ургалтын явцыг анхаарч, хяналт тавьж, баримтжуулан жил бүр тарьсан мод болон ургалтын тоо, чанараг хянан үр дүнг тооцож хэвших,

19. Байгууллагын хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр үр дүнтэй арга, туршлага нэвтрүүлж, хэвшил болгох,

20. E-mongolia цахим систем хэрэглэгч байгууллагууд тухайн салбар, нэгжийн үйлчилгээний төрөл, үр дүнг цахим хуудсандаа байршуулбал зохистой.

ЗӨВЛӨМЖ ХЯНАСАН:



Л.ОТГОНБАЯР

Хяналт-шинжилгээ, үнэлгээний
хэлтсийн даргын албан ўргийг хавсралтад
гүйцэтгэгч

ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛСАН:

Н.АЛДАРМАА

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан
мэргэжилтэн